

тохиолдолд хариуцлага хүлээлгэх, албаны чиг үүргээ хуульд заасан нөхцөл шаардлагад нийцүүлэн биелүүлснээс үүдэх үр дагаврыг шийдвэр гүйцэтгэгч өөрөө хариуцахгүй байх зэрэг эрх зүйн баталгааг практик дээр бүрэн дүүрэн хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх шаардлагатайгаас гадна, эрх зүйн болон нийгмийн баталгааг бүрдүүлэхдээ шийдвэр гүйцэтгэгчдийн ажил үүргийн онцлог тус бүрийг харгалзан үзэх нөхцлийг бүрдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчдийн амь насыг улсаас албан журмаар даатгаж, зардлыг төр өөрөө хариуцах зэргээр бусад орны ижил төсөөтэй байгууллагуудын үйл ажиллагаанаас сайн туршлагыг нэвтрүүлэх боломжтой гэж үзэж байна.

Энэхүү илтгэлд дурдагдсан мэдээллийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хууль сахиулагчдын эрх зүйн болон нийгмийн баталгааг бүрдүүлэх чиглэлээр хийсэн судалгаан дээр үндэслэн боловсруулсан бөгөөд судалгаанд дурдагдсан асуудлыг Хууль зүйн яамнаас санаачлан боловсруулсан Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгах чиглэлээр Комисс хамтран ажилласан болохыг энд дурдахыг хүсч байна.



Ж.УУГАНЧИМЭГ

Хууль сахиулахын их сургуулийн Ерөнхий эрдмийн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах, багш

ИХ ЗАСАГ ХУУЛЬ ДАХЬ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Иргэний эрх зүй нь өнө эртний түүхэн уламжлалтай, өөртөө зохицуулах зүйл, зохицуулалтын арга, нийгэмд гүйцэтгэх үүрэгтэй бие даасан томоохон салбар эрхзүй юм. Иргэний эрх зүй” хэмээх нэр томъёо нь эртний Ромын эрхзүйгээс гаралтай. Ромын иргэд эд хөрөнгөө өмчлөх, эзэмших эрхтэй гэсэн үзэл, сэтгэлгээ бий болж улмаар тэр нь эрх зүйгээр баталгаажин эрх зүйн системд **JUS CIVIL** буюу Иргэний эрх зүй гэсэн салбар болон үүсэн хөгжсөөр бидний үед хүрч ирсэн.

Манай улсын хувьд төрт ёс үүссэн тэр цагаас эхлэн тухайн нийгмийнхээ хөгжилд тохирсон эрх зүйн зохицуулалтуудыг хийсээр ирсэн юм.

Иргэний эрх зүйн зохицуулах зүйл нь гол төлөв хүмүүсийн өдөр тутмын хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн ахуйн болон аж ахуй, эдийн засгийн ойлголттой ямар нэг хэмжээгээр холбоотой илэрдэг бөгөөд эрх зүйн төдийгүй зан заншил, ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулагдаж байв.

Сүүлийн үед салбар эрх зүйн шинжлэх ухааны онолын үүднээс тухайн үеийн зохицуулалтуудыг ангилан авч судлах нь нилээд түгээмэл болсон байна. Иймээс Монгол улсын Иргэний эрх зүйн зохицуулалтыг эрх зүйн түүхийн үечлэлийг

баримтлан авч үзэх нь зүйтэй юм¹⁷.
Тухайлбал:

1. Эртний үеийн Иргэний эрх зүй
2. Дундад үеийн Иргэний эрх зүй
3. Шинэ үеийн Иргэний эрх зүй
4. Нэн шинэ үеийн Иргэний эрх зүй

Их засаг цааз нь Дундад үеийн иргэний эрх зүйн хөгжилд хамаарагдах, энэ үед нийгмийн харилцааг зохицуулж байсан, түүхэн ач холбогдол бүхий Монголын анхны хууль цаазын бичиг. Уг хууль бол Монголын феодалын нийгмийн харилцаа, төрт ёсны үеийн гол хууль бөгөөд эзэн Чингисийн үеэс зарлиг, тогтоол, ихэс дээдсийн үүрэг даалгаврын хэлбэрээр гарч байсан хэм хэмжээнүүдийг нэгтгэн эмхтгэж төрийн хууль болгон тунхагласан байна. Энэ хууль нь бидний үед бүрэн эхээрээ уламжлагдан ирээгүй бөгөөд эрдэмтдийн судалгаанаас үзэхэд Орос,Хятад, Америк, Англи, Япон, Герман, Итали, Турк, Египет зэрэг орны 100 гаруй эрдэмтэн, судлаачид зохиол бүтээлдээ уг хуулийн талаар тусгайлан авч үзэж, ном, өгүүлэл туурвисан байдаг.

Их засаг хуулийн судалгааг:

1. Эх сурвалжийн шинж бүхий бүтээл
2. Судалгааны ном зохиол хэмээн хоёр ангилж болох юм.¹⁸

Их засаг хуулийн талаар судалгааны ном, зохиол, өгүүлэл олон гарсан бөгөөд ялангуяа Оросын В.В. Бартольд, В.А. Рязновский, С.Д. Дылыков, В.Г. Владимирцов, Өвөр Монголын Сайшаал, Тайваны Ли-Цифин, Японы Ш.Озава, Мураками, Америкийн Ж.Вернадский, Монголын Л.Дэндэв, Х.Пэрлээ, Ш.Нацагдорж, Н.Ишжамц, Д.Гонгор, С.Жалан-Аажав, Э.Авирмэд,

Г.Совд, Б.Чимид, И.Дашням нарын зэрэг эрдэмтдийн бүтээл “Их засаг” судлалд чухал хувь нэмэр оруулсан юм.

“Их засаг” цаазад ихэнхдээ засаг захиргаа, цэрэг, эрүүгийн гэмт хэрэг, түүнд оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэлбэрийн заалтууд байх ба харин аж ахуйг эрхлэн хөтлөх болон иргэд хоорондын өмч, эд хөрөнгөтэй холбогдож үүссэн төрөл бүрийн харилцаа ихэнхдээ уламжлалт зан заншлын хэм хэмжээгээр зохицуулж байсан учир иргэний чиглэлийн заалт цөөн байжээ.¹⁹

Судлаачдын бүтээлээс үзэхэд “Их засаг” хуулийн агуулгыг төр засах цааз, иргэний аж байдлын цааз, эрүүгийн бодлого гэсэн гол асуудлуудад төвлөрүүлэн зангидаж тайлбарласан байна.²⁰ Дээрхи судлаачдын бүтээлийг иш үндэс болгон “Их засаг” цааз пахь иргэний эр зүйтэй холбогдох заалтуудыг ялган авч тэдгээрийг судлахыг оролдсон юм.

Иргэний аж байдлын цаазад ахуй заншил, иргэд хоорондын харилцаа, сургаал, сургамж, тэтгэвэр, тэтгэмж, өмч хөрөнгө, өв залгамжлал, гэрлэлт, гэр бүл, арилжаа, худалдааны шинжтэй хэм хэмжээнүүдийг хамааруулан заасан байдаг.

Уг хуульд Иргэний эрх зүйтэй холбоотой заалт ховор, тэр бүр нарийвчилж зааж өгөөгүй боловч зарим тохиолдолд иргэний эрх зүйд холбогдох зохицуулалтыг агуулсан байдаг. Жишээ нь: “Их түшмэд бусад ард иргэд үхсэн хойно хэн ч энэ эд хөрөнгөд нь халдаж болохгүй, үхэгсэд залгамжлах үр хөвгүүнгүй болбоос эд хөрөнгийг түүний шавь буюу зарцад өгч болохоос биш, улсын санд оруулж болохгүй” гэж заасан.²¹

¹⁷ Ж.Ууганчимэг “Иргэний эрх зүйн лекцүүд” УБ..2012 он 26-р тал

¹⁸ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ..1999 он. 70-р тал

¹⁹ Т.Мөнхжаргал “Монгол Улсын иргэний цаазын товчоон” УБ.. 2006 он 54-р тал

²⁰ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар “Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ..1999 он 71-р тал

²¹ О.Отгонтуяа “Иргэний эрх зүй” УБ..2012 он 22-р тал

Мал маллах, ан гөрөө хийх, тариа тарих, худалдаа, арилжаа эрхлэх, өв өвлөх гэх мэт аж ахуйн үйл ажиллагаа нь монголчуудын аж амьдралын язгуур эх сурвалж байсан учраас түүнийг төрийн бодлого болгон Их засаг хуульд тусгагдаж байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг. Их засаг хуульд аж ахуйн үйл ажиллагааг зохицуулсан иргэний эрх зүйн хэм хэмжээг олон талаас нь нарийвчлан задалж дэлгэрэнгүй заагаагүй бөгөөд энэ нь тухайн түүхэн цаг үе, нөхцөл байдалтай холбоотой.

22

1. Их засаг хуулийг гаргах үед аж ахуй, эд хөрөнгөтэй холбоотой харилцааг ихэнхидээ заншлын хэм хэмжээгээр зохицуулж байсан.
2. Хүмүүс сайн дураараа заншлын хэм хэмжээг үл биелүүлж бусдыг хохироох тохиолдол гарах болсон нь түүнд төрийн зохицуулалт, албадлага зайлшгүй шаардлагатай зарим харилцааг эрх зүйн хэм хэмжээ болгон заасан.
3. Монголчууд төрөө эмхлэн байгуулж, хууль цаазаа зохиож эхлэсэн цаг үед иргэний эрх зүйн хэм хэмжээг нарийвчлан задалж төрөлжүүлэн заах хүмүүсийн эрхийн ухамсар, танин мэдэхүй дутагдалтай байсан.

Мөн Их засаг хуульд **ямар нэгэн хүн эд таваар дам авч худалдан гурван удаа алдваас цаазалсугай гэсэн заалт байдаг.**²³ Энэ заалтыг өнөөдрийн байдлаар авч үзвэл ихэд сонирхолтой бөгөөд бодоход худалдаа арилжаа нь хүний амьдрал ахуйн зайлшгүй хэрэгцээ болохыг, үүний тулд худалдаа хийж сурахыг, хэрэв алдагдалтай хийвэл

өөртөө болон гэр бүлдээ хохирол учруулбал цаашид дан худалдаа эрхлэхийг болих нь зүйтэй гэсэн үүднээс эрх зүйн хэм хэмжээ болгон заасан хэрэг болов уу гэж санагдаж байна.

Их засаг хуульд Их түшмэд ноёд бусад ард иргэд үхсэн хойно түүний эд хөрөнгө хэдий байсан ч болтугай хөндлөнгөөс ингэ, тэг гэж үл болох бөгөөд хэн ч энэ эд хөрөнгөнд халдаж болохгүй. Үхэгсэд залгамжлах үр хөвүүнгүй болбоос эд хөрөнгийг нь түүний шавь буюу зарцад өгч болохоос биш, улсын санд оруулж огт болохгүй гэсэн заалт байдаг. Мөн талийгаачийн өмч хөрөнгийг хууль ёсны өмчлөгчөөс өөр хүн ашиглахыг хатуу хориглоно гэж заасан²⁴.

Эдгээр заалтыг ажиглахад нас барагчийн өв хөрөнгийг юуны өмнө үр хүүхэд өвлөн авах, хэрэв үр хүүхэдгүй бол талийгаачийн шавь, зарцад өгч байхаар тогтоосон. Энд нэгэн сонирхолтой нь шавь, зарц хууль ёсны өв авах эрхтэй хүмүүсийн эрэмбэ дараалалд орсон явдал юм. Талийгаачийн гэргий өв авна, авахгүй бол гэж зориуд нэрлэн заасан зүйл байдаггүй бөгөөд энэ нь үр хүүхэд шилжсэн өв хөрөнгө тэртэй, тэргүй эхэд нь оногдох ёстой гэсэн үзэл бололтой. Харин үр хүүхэдгүй байвал, өв хөрөнгө шавь буюу зарцад шилжих боломжтой юм гэснийг тогтоосон заалт юм.

Их засаг хуульд өв залгамжлалтай холбоотой нэгэн сонирхолтой заалт байдаг. “Байлдааны талбайд амь үрэгдэгсдийг боол зарц нь үүрэн гарч ирсэн бол түүний мал хөрөнгийг боолд нь өгөх хэрэгтэй. Өөр хүн

²² Монголын түүхийн эрх зүйн баримт бичгийн эмхтгэл 1999 он

²³ Л.Дэндэв. “Монголын эрт эдүүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв” УБ., 1936 он 8-дахь тал

²⁴ С.Цэрэнбалтав, Ц.Минжиг “Чингис хааны Их засаг хууль” УБ., 2003 он 184 дэх тал

үүрч гарч ирвэл амь үрэгдсэн хүний гэргий, боол, зарц мөн эд хөрөнгийг цөмийг нь энэ хүнд өгөх хэрэгтэй” гэж Сайшаал бичсэн байна.²⁵ Энэ зүйлийг нягтлавал эх орон газар нутгаа хамгаалах ариун үүргийн ёсоор эр зоригтой тулалдаж яваад амь үрэгдэгсдийг хөсөр орхилгүй дайны талбараас авч ирсэн хүнийг хүндэтгэн үзэж байсан учраас хууль буюу гэрээслэлээр өв авах эрхгүй хөндлөнгийн хүнд талийгаачийн өв хөрөнгийг шилжүүлэх нь өв залгамжлалын нэг хэлбэр байв хэмээн үзэж болно. Харин түүнд гэргий, боол, зарцыг шагнаан өгч байсныг өвлөх эрх буюу өв залгамжлалын харилцааны объект байсан гэж дүгнэж болохгүй.

Харин Амь үрэгдэгсдийг авч ирсэн хүнд эд хөрөнгийг өвийн журмаар өгөх, харин гэргий хүүхэд, боол зарц нарыг замд нь орхих бус тэднийг ядуу зүдүү гуйлгачин болохоос урьдчилан сэргийлж, амьдрал ахуйг харж хамгаалах зорилгыг агуулсан заалт гэж үзэх нь зүйтэй. Мөн “итгэмжийн өртөөгөөр бараа таваарыг зөөвөрлөж байгаад өртгөө алдсан ба нэгэн удаа итгэлийн өртөг олж хоёр дахь удаагаа бараа таваар зөөвөрлөж болно. Гэвч гурав дахь үнэ өртгөө алдсаныг алах ялаар шийтгэмүй” гэж уг цаазад тэмдэглэсэн байдаг. Энэ нь иргэд хоорондын энгийн худалдаагаар алдах, онохыг хэлээгүй бөгөөд харин бусдаас итгэмжлэн авсан мөнгө, эд юмс, өөрөөр хэлбэл бусдаас өөрийн ахуй амьдралаа дээшлүүлэх зорилгоор шилжүүлж авсан эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, ашиг олж чадаагүй гурван удаа өр алдсан этгээдийг цаашид ийм зээл, худалдаа эрхлэхийг хориглосон заалт байсан гэж үзэж байна.

Их засаг цаазын Иргэний цаазад холбогдох зүйл заалтыг бүхэлд нь авч үзвэл Чингис хааны толгойлон эмхлэн байгуулсан Их гүрний төрийн чиг үүргийн нэг чухал чиглэл нь улс орны гадаад дотоод эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, монголчуудын амьжиргааны язгуур үндэс болох мал аж ахуйг эрхлэн хөтөлж ирсэн уламжлалт арга ажиллагааг улам бүр боловсронгуй болгох, газар, ус ан амьтан, байгаль орчноо хайрлан хамгаалж зүй зохистой ашиглах явдал байв. Энэхүү бодлогыг амьдралд хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт үүргийг Их засаг цааз гүйцэтгэж байлаа.

Ард иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэх зорилгоор эрт үеэс заншлын хэм хэмжээгээр зохицуулж ирсэн эд хөрөнгө олж авах, арилжаа худалдаа хийх, өв өвлөх, гэрлэх ёс журмыг төрийн бодлогын түвшинд онцгойлон анхаарч төрийн хуулийн хэлбэрт оруулж өргөмжлөн тогтоосон байна.

Эцэст нь дүгнэж үзвэл Их засаг цааз бол зөвхөн монгол туургатны төдийгүй дэлхийн ихэнхи улс орны хууль зүйн болон эрх зүйн шинжлэх ухаан, сэтгэлгээний үүсэл, хөгжлийг агуулсан судалгааны үнэлж баршгүй түүхэн ач холбогдолтой эх сурвалж юм.

²⁵²⁵ Сайшаал “Чингис хааны товчоо” Хөх хот., 1987 он 486-р тал